



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 5/46

Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

“Төрийн албаны тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.5 дахь заалтууд, 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 46.1, 46.4 дэх заалт, албаны даргын дэргэдэх зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн № 02 тоот хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны 2013 оны хагас жилийн ажлын тайлангийн хурал, даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан сургалтанд амжилттай суралцсан Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Баярхүү, мэргэжилтэн Б.Баясгалан нарт тус бүрд нь 50,000 /тавин мянга/ төгрөгийн урамшуулал олгосугай.

2. Урамшуулалд олгох 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийг урьд оны төсвийн хэмнэлтийн зардлаас бодож олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН